

ХОВД СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН 2016-2019 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Нэг. Шалгалтын зорилго

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Ховд аймгийн Ховд сумын төсөвт байгууллагуудын 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга, Улсын ахлах байцаагч Г.Өөдэй, Улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш, Улсын байцаагч Ц.Бадрал, Д.Болормаа П.Мягмартүвшин, дотоод ажилтан Н.Балт нар 2020 оны 03 сарын 02-нээс 03 сарын 25-ны хооронд хяналт шалгалтаар ажиллав.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Тус байгууллагуудын 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Тус байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын бусад хууль эрхзүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн улсын төсвөөс батлагдсан төсвийн санхүүжилтийг

зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, эргэлтийн хөрөнгийг олж бэлтгэн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилттой ажиллаж иржээ.

Шалгагдах хугацааны хөрөнгийн эрх захирагчийн нэгдүгээр гарын үсгийг Засаг дарга Ш.Ерболат, ИТХ-ын нарийн бичгийн дарга Х.Тилеухан, А.Есенболды, ЗДТГ-ын дарга Х.Өнерхан, сургуулийн захирал Д.Манат, Я.Өмирхан, Цэцэрлэгийн эрхлэгч Т.Амангельд, Т.Айнашхан, ЭМТ-ийн эрхлэгч эмч А.Алтанбек, Н.Бэрхбол, Д.Ахгүл, Соёлын төвийн эрхлэгч Х.Аманбол, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Дүйсенбек, Т.Күлия, Х.Алия, Х.Депудатхан, Х.Бүлдиршин, М.Ахмадий, Т.Ернур нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, Санхүүгийн албаны дарга Д.Жолды, төрийн сангийн мэргэжилтэн Х.Володя нар хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны дарга, Улсын ахлах байцаагч Г.Өөдэй Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан ИТХ, Улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш ЗДТГ, Улсын байцаагч Ц.Бадрал Эрүүл мэндийн төв, Соёлын төв, ИТХ, Улсын байцаагч Д.Болормаа, дотоод ажилтан Н.Балт нар Сургууль, Улсын байцаагч П.Мягмартүвшин Цэцэрлэгийн баримтыг тус тус шалгалаа.

Тав. Төсвийн бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн талаар

Төрийн сан: Ховд сум нь татварын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 2016 онд 33.4 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 25.0 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 8.4 сая төгрөгөөр 75.8 хувиар, 2017 онд 26.3 сая төгрөгийн төлөвлөгөөтэй байснаас 32.1 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 5.8 сая төгрөгөөр буюу 122 %-аар, 2018 онд 33,3 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 46.4 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 139%-аар тус тус биелүүлжээ.

Татварын орлогын төлөвлөгөөг төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Д/Д	Татварын төрөл	2016 он		2017		2018 он		2019 он	
		Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
1	Сум	33400.0	41945.4	26340.0	32100.0	33350.0	46385.1	42755.0	116025.2
2	Аймаг	91800.0	98793.6	91180.0	104498.7	89650.0	95344.4	86710.5	68881.3
3	Улс	3100.0	4656.5	4000.0	4418.0	3100.0	3883.1	4010.0	3268.5
	Дүн	128300.0	145395.5	121520.0	180778.7	1126100.0	145612.6	133475.5	187175.0

5.1 Ховд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2016 онд 2 орон тоотой, орон нутгийн төсвөөс 43440.2 мянган төгрөгийн төсөвтэй ажилласнаас, гүйцэтгэлээр 43475.2 мянган төгрөг зарцуулжээ.

Оны эхэнд авлагагүй байсан бол оны эцэст 453.1 мянган төгрөг болж 453.1 мянган төгрөгөөр өссөн.

Оны эхэнд өглөггүй байсан бол оны эцэст 1064.8 мянган төгрөг болж 1064.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өглөг нь НДШ-ийн өглөг байна.

2017 онд 2 орон тоотой, орон нутгийн төсвөөс 69399.0 мянган төгрөгийн төсөвтэй ажилласнаас, гүйцэтгэлээр 69639.9 мянган төгрөг зарцуулжээ.

Авлага 453.1 мянган төгрөг байсан бол оны эцэст авлага 453.1 мянган төгрөг болж хэвээр байна.

Өглөг 470.4 мянган төгрөг байсан бол оны эцэст өглөг 470.4 мянган төгрөг болж хэвээр байна.

2018 онд 2 орон тоотой, орон нутгийн төсвөөс 42970.6 мянган төгрөгийн төсөвтэй ажилласнаас гүйцэтгэлээр 42540.5 мянган төгрөг зарцуулж 430.1 мянган төгрөгийн төсөв хэмнэсэн байна

Авлага 453.1 мянган төгрөг байсан бол оны эцэст авлагыг бүрэн барагдуулсан байна.

Өглөг 470.4 мянган төгрөг байсан бол оны эцэст өглөгийг барагдуулсан байна.

2019 онд 2 орон тоотой, орон нутгийн төсвөөс 47500.6 мянган төгрөгийн төсөвтэй ажилласнаас гүйцэтгэлээр 47500.6 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

Оны эцэст ХАОАТ-ийн 163.2 мянган төгрөг дутуу шилжүүлж өглөгт бүртгэсэн байна.

Өмнөх шалгалтын талаар:

2016, 2017, 2018, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авч байсан байна.

Шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар:

1. 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 9947**** утасны төлбөрийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.4 дах заалт, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын 2 дах хэсгийн в.2 дах заалт, хэмнэлтийн горимыг зөрчсөн.

2. 2018 оны 10 дугаар сарын 04-нд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтын байр, хоолны төлбөр 750000 төгрөг “Оюумандал” ХХК руу, “Ич гүрэн” ХХК руу материалын үнэ 148000 төгрөг, 1102000 төгрөгийг тэмцээний шагнал, сумын Иргэдийн Хурлын Төлөөлөгч, багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн Засаг дарга нарт шатахуун олгосон. Нийтдээ 2000000 төгрөгийг үргүй зарцуулсан.

Шалгалтаар нийт 2020000 төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байхыг үүрэг болголоо.

Дүгнэлт:

Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтанд тулгуурлаж хөтлөөгүй, санхүүгийн хяналт сул, холбогдох хууль, эрхзүйн актыг мөрдлөг болгон ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тус байгууллагад анхан шатны баримтыг бүрдүүлж гүйлгээ хийх, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, санхүүтэй холбоотой хууль, эрх зүйг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах зөвлөмжүүдийг өглөө.

5.2 Засаг даргын тамгын газар

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Тус байгууллага нь 2016 онд төсвөөс 278713.6 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 271200.6 мянган төгрөгийн зардал гаргаж батлагдсан төсвийг 7513.0 мянган төгрөгөөр хэмнэн зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

2016 онд авлага 53.4 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд барагдуулаагүй байна. Харин өглөгийн үлдэгдэлгүй байна.

2017 онд төсвөөс 310458.8 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 310221.8 мянган төгрөгийн зардал гаргаж 236.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

2017 онд авлага 53.4 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд барагдуулаагүй байна. Харин өглөгийн үлдэгдэлгүй байна.

2018 онд төсвөөс 330053.5 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 329796.7 мянган төгрөгийн зардал гаргаж 256.8 мянган төгрөгөөр хэмнэн зарцуулж үйл ажиллагаа явуулжээ.

2018 онд авлага 53.4 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд барагдуулаагүй байна. Харин өглөгийн үлдэгдэлгүй байна.

2019 онд төсвөөс 319685.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 50.0 мянган төгрөг, нэмэлт дансаар 48826.1 мянган төгрөг нийт 368561.1 мянган төгрөгөөр зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 366063.1 мянган төгрөгийн зардал гаргаж нэмэлт дансанд 2498.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлж үйл ажиллагаа явууллаа.

2019 оны эхэнд 53.4 мянган төгрөгийн авлагатай байсан бол тайлант оны эцэст 861.5 мянган төгрөгийн авлагатай байна. Харин өглөгийн эхний үлдэгдэлгүй тайлант жилд 984.5 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны нэмэлт дансаар:

Өвсний орлого 4148.3 мянган төгрөг, мал тооллогын санхүүжилт 449.5 мянган төгрөг, дээд шатнаас 6740.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын хэлтэсээс 3612.4 мянган төгрөг, Модны орлого 1502.0 мянган төгрөг, дэнчингийн орлого 1195.2 мянган төгрөг, Дуудлага худалдаа тендерийн орлогоос 388.6 мянган төгрөг, хандивийн орлого 115.0 мянган төгрөг, Их засвар 675.0 мянган төгрөг бүгд 18826.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Дээрх орлогоос шатахууны зардалд 2275.8 мянган төгрөг, татварт 498.2 мянган төгрөг, лист 3612.4 мянган төгрөг, өвс тэжээлийн зардалд 4349.7 мянган төгрөг, Дэнчинд 470.4 мянган төгрөг, материалд 645.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогонд 449.5 мянган төгрөг, Интернетийн төлбөрд 1992.3 мянган төгрөг, Наурызын баярт 900.0 мянган төгрөг, их засвард 675.0 мянган төгрөг, актын төлбөрд 450,0 мянган төгрөг, Морины гарааны төхөөрөмжийн зардалд 2200.0 мянган төгрөг, Өв соёлын өдөрлөгт 850.7 мянган төгрөг, Хүүхэд хамгаалах бодлого сурталчилах аяны зардалд 254.7 мянган төгрөг зарцуулж, үлдэх 17431.3 мянган төгрөгийг төвлөрүүлж оны эцэст харилцах дансанд үлдэгдэлгүй байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны нэмэлт дансаар:

2018 оны Татан төвлөрүүлсэн мөнгийг буцааж олгосон 17431.3 мянган төгрөг, өвсний орлого 2841.5 мянган төгрөг, мал тооллогын санхүүжилт 1927.6 мянган төгрөг, дээд шатнаас 42599.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын хэлтэсээс 242.4 мянган төгрөг, төмрийн орлого 100.0 мянган төгрөг, цахим тендерийн орлогоос 346.5 мянган төгрөг, дэнчингээс 11.5 мянган төгрөг, Наурызын баярын үйл ажиллагааны зардалд 1000.0 мянган төгрөг бүгд 49068.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Дээрх орлогоос тэргүүний багаар шалгарсан шагналын зардалд 270.0 мянган төгрөг, татварт 60.0 мянган төгрөгийг, лист 242,4 мянган төгрөг, бараа материал, бичиг хэргийн зардалд 2932.2 мянган төгрөг, томилолтын зардалд 6000,0 сая төгрөг, машин худалдан авсан зардалд 33999.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого болон байшин, орон сууцны тооллогод 1927.6 мянган төгрөг, шатахууны зардалд 738.3 мянган төгрөг, ахмад ачल्या хөтөлбөрд 100.0 мянган төгрөг, урамшуулалд 261.0 мянган төгрөг, тендерийн зардалд 50.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэх 2498.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж оны эцэст харилцах дансанд үлдэгдэлгүй байна.

Сумын 70 жилийн ойн талаар: Сумын ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар сумын ИТХ-ын 2017 оны 01 сарын 18-ны өдрийн 03-р тогтоолоор 18-20-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр баталсан байна.

Ойд зориулан 2017 онд хандив цуглуулан ЗДТГ-ын нэмэлт дансаар төвлөрүүлэн зарцуулжээ. Сумын 5 багаас нийт 344 иргэн, 8 аж ахуйн нэгж

байгууллагаас 100.6 сая төгрөгийн хандив төвлөрч ойн арга хэмжээнд зарцуулсан байна. Хандив өргөсөн өрх бүрт 70 жилийн ойн медаль дурсгалын шаазан аягын хамт 500.0-1000.0 сая төгрөгийн хандив өргөсөн иргэдэд үндэсний домбор хөгжим, 1.0-5.0 сая төгрөг хандив өргөсөн иргэдэд дунд гарын мөнгөн аяга, 5 сая-аас дээш хандив өргөсөн 3 иргэнд их гарын мөнгөн аягыг дурсгал болгон өгсөн байна.

Сумын ойтой холбоотой дансанд болон бэлнээр цугласан 106.0 сая төгрөгийг дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

- Бүтээн байгуулалтанд 13764.5 мянган төгрөг
- Ойн медальд 7800.0 мянган төгрөг
- Урилга 2240.0 мянган төгрөг
- Хүндэт тэмдэг 700.0 мянган төгрөг
- Бүжгийн хувцас 800.0 мянган төгрөг
- Булэг дурсгалд 9198.0 мянган төгрөг
- Шатахууны зардалд 9504.4 мянган төгрөг
- Цайллага хүлээн авалтанд 20342.8 мянган төгрөг
- Морины шагналд 16077.6 мянган төгрөг
- Бөхийн шагналд 5816.0 мянган төгрөг
- Айтыс 1211.6 мянган төгрөг
- Көкпар 156.0 мянган төгрөг
- Тенге илү 156.0 мянган төгрөг
- Ном 2000.0 мянган төгрөг
- Хэвлэлийн үнэ 3013.1 мянган төгрөг
- Ажлын хөлс 3309.1 мянган төгрөг тус тус зарцуулж үлдэгдэл 4510.4 мянган төгрөг үлдсэн байна.

Түүхт 70-н жилийн ойн баярын урилгын эхийг бэлтгэх, хэвлүүлэх, ахмад настангуудын зураг авах, угаалгах, ойн баярын тенге илүү, айтыс тэмцээн зэрэг бусад арга хэмжээнүүдийн өргөмжлөл, дурсамж хэвлүүлэх ажлыг Ховд аймгийн Жаргалант сумын төвд үйл ажиллагаа явуулдаг “Енто дизайн” ХХК-р гүйцэтгүүлсэн. Ойн баярын хурдан морины медаль, үндэсний бөхийн барилдааны медаль, батламж, өргөмжлөл хийлгэх ажлыг Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг “Титэм плаза” ХХК-р бэлэг дурсгалын мөнгөн аягыг “Зоос гоёл” ХХК-р, бэлэгний уут, уяач хүүхдүүдийн номер хийлгэх ажлыг Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг “Ич гүрэн” ХХК-р, домборыг Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулдаг “Арман алтын домбыра” ХХК-р бэлэг дурсгалын аягыг “Жасар” ХХК-р гүйцэтгүүлэхээр тус тус гэрээ байгуулан хамтран ажилласан байна. Сумын 70-н жилийн ойн үйл ажиллагааг аудитын газрын зөвлөмжийн дагуу сумын ард иргэд, багуудад танилцуулсан байна. Аудитын газрын албан шаардлагаар

шатахууны анхан шатны баримт бүрдээгүй байсныг замын хуудас болон бусад анхан шатны баримтын бүрдэлийг ханган ажилласан байна.

Өмнөх шалгалтын талаар:

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн ба түрээсийн гэрээ байгуулсан боловч түрээсийн орлого оруулаагүй, элэгдэл зөрүүтэй тооцсон зэрэг зөрчил илэрсэнийг албан шаардлагаар арилган шинэ түрээсийн гэрээ байгуулан ажилласан байна.

2017-2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалтай” санал дүгнэлт авсан байна.

2017 онд мал эмнэлэг үржлийн албанд үнэ төлбөргүй ирсэн 2.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

2018 онд “Ортасу” ХХК-д бензины үнэ 18532.3 мянган төгрөг шилжүүлж бараа материалын тайланд 15060.3 мянган төгрөгөөр орлого авч 3472.0 мянган төгрөгийн шатахууныг орлого аваагүй байна.

Телейханаас урьдчилгаа 100.0 мянган төгрөг дутуу суутган авсан. Жолоочийн тооцооны хуудасгүй 1723.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Шөкэлэй мал эмнэлэгийн нэр бүхий 11 малчны 3 төрлийн 693.2 мянган төгрөгийн тарилгын акт малчны гарын үсэг тамга тэмдэггүй.

Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитад хугацаа хоцорч ирүүлсэн, санхүүгийн тайланг програм хангамж ашиглан гаргадгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба зөрчил илрээгүй байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Няравын хувийн харилцах дансанд 2018 онд 5.9 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн боловч тооцоо бодоогүй, 2016-2018 онуудад өвс тэжээлийн тооцоо бодоогүйтой холбоотой 2018 оны өвс тэжээлийн тооцооноос нэр бүхий 4 хүнээс 0.3 сая төгрөгийн өвс тэжээлийн үнийг авахаар байгаа боловч өвсний тооцоо бодоогүй, авахаар авлага дансанд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2. дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1, 7.6. дахь заалтыг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэхь заалт

2. 2017 оны 12 сард төрийн албан хаагчидад олгох нэг удаагийн тэтгэмжийн даргын тушаалаар арга хэмжээтэй 4 ажилтанд 1.0 сая төгрөг, 2018 онд нэр бүхий 7 ажилтанд 1.8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.6 дахь заалт, Улсын их

хурлын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 67 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдааны 2017 оны 12 сарын 6-ны өдрийн 52 дугаар тэмдэглэлийг

3. Суудлын автомашинд дугуй, аккумулятор, бусад сэлбэг худалдан авахдаа ажилласан хугацааг тооцоогүй, жолоочийн хувийн харилцах дансанд зарим тохиолдолд сэлбэгийн үнийг шилжүүлж өгсөн нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалын 9, 10 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2. дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1, 7.6. дахь заалтыг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэхь заалт

4. Монгол улсын Засгийн газрын тогтоол зөрчиж цайллага, хүлээн авалтад 2016 онд 914400 төгрөг, 2017 онд 2.0 сая төгрөг, 2018 онд 3907208, 2019 онд 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан, 0.8 сая төгрөгийн бараа материалыг тушаал шийдвэргүй анхан шатны баримт бүрдээгүй, юунд зарцуулсан нь тодорхой бус байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 147-р тогтоолын 4 дэх, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын 2.в.2, 2.в.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 122 тоот тушаалын нэг дэх хэсгийн 4 дэх заалтыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.6, 9 дүгээр зүйлийн 9.1 дэхь заалтыг

5. Засаг даргын тамгын газрын ажилтанд нууцын нэмэгдэлд 2018 оны эхний 4 сард 0.2 сая төгрөгийг илүү тооцон олгосон нь Засгийн Газрын 2017 оны 246-р тогтоолын 4-р хавсралтын 1.2 дахь заалт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг

6. Зарим нэр бүхий ажилтанд амралт цалинг давхардуулан 0.4 сая төгрөгийг илүү тооцон олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 55 дугаар зүйлийн 55.1 дахь заалтыг

7. Ховд сумын ЗДТГ-нь 2018-2019 оны эхний хагас жилийн шатахууныг замын хуудсанд явсан келометрээс илүү тооцон 0.6 сая өгрөгийн шатахуун, 0.7 сая төгрөгийн шатахууныг албаны машинд зарлага болгосон боловч замын хуудасгүй хаана явсан нь тодорхой бус, нийт 1.3 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн, 7.1, 7.5, 7.6, 7.7 дахь заалтууд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 19 тоот тушаал, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалуудыг

Шалгалтаар ЗДТГ-т нийт 20,926,327 төгрөгийн зөрчил илрүүлж 6,250,853 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар улсын ахлах байцаагчийн акт тогтоож 14675474 төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг болголоо.

Дүгнэлт:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, Цалин тэтгэмж олгоходоо хууль эрх зүйг зарим тохиолдолд мөрдөөгүй олгосон, шатахууны тооцоо бодолгүй явсан келометрыг илүү тооцон бичсэн, тушаал, шийдвэр хууль, эрх зүйг зөрчиж дайллага болон үргүй зардалд ихээхэн хэмжээний мөнгө зарцуулсан, нягтлан бодогч няравын тооцоог бодож тайлан тооцоонд өглөг авлагыг тооцон тусгадаггүй зэрэг зөрчлүүд байна.

Өгсөн зөвлөмж:

Ховд сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт аливаа хөрөнгө мөнгийг бүрдэл болсон, хүчин төгөлдөр үнэн зөв баримтаар гүйлгээ хийх, суудлын автомашинд хугацаатай эд зүйлс, шатахуун тавьж олгоход стандартын дагуу норм нормативыг тооцох, явсан келометрийг үнэн зөв бичиж тооцоо хийх, төсвийн хөрөнгөөс цайллага дайллага, хүлээн авалт, бэлэг сэлтийг төсөвлөгдсөн хэмжээнд зохих хууль эрх зүйг мөрдөх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад анхаарах, Засаг даргын тамгын газрын бүртгэлтэй хөрөнгө болох зоорь, трактор, халуун ус, байр зэргийг түрээслүүлэх, ашиглах, хамгаалахад албан ёсны гэрээ хийж зохих орлогыг тооцоолж авах, дотоод хяналтыг сайжруулж, санхүүгийн хариуцлагыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг өглөө.

5.3 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

Ховд сумын ОНХС нь 2016 онд 6 ажилд 76100.0 мянган төгрөг батлагдаж, ажлуудыг санхүүжүүлэхээр баталсан ажилд 38400.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцэст 31700.0 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Зориулалт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
2015 оны үлдэгдэл 6000.0			
1	Цагаанбургас багийн мал угаах ванн барих	7700.0	7700.0
2	Баруунсалаа багийн мал угаах ванн барих	7800.0	7800.0
3	Баяр наадмын зардал	4900.0	4900.0
4	Интернетийн үйлчилгээ	4000.0	4000.0
5	Хөтөлбөр арга хэмжээ	13000.0	13000.0
6	ИТХ-ын хөтөлбөр арга хэмжээ	1000.0	1000.0
	Дүн	38400.0	38400.0

Ховд сумын ОНХС нь 2017 онд 41400.0 мянган төгрөг батлагдсаныг доорх ажилд хувиаралсан.

№	Бараа ажил, үйлчилгээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Наадмын талбайн их засвар	30900.0	30900.0
2	ИТХ-ын хөтөлбөр арга хэмжээ	500.0	500.0
3	Хөтөлбөр арга хэмжээ	4000.0	4000.0
4	Баяр наадмын зардал	6000.0	6000.0
	Дүн	41400.0	41400.0

Ховд сумын ОНХС нь 2018 онд 57124.4 мянган төгрөг батлагдсаныг доорх ажилд хувиаралсан.

№	Бараа ажил, үйлчилгээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Баруун салаа багийн мал угаах ванн барих	7800.0	7800.0
2	Хүүхэд залуучуудын парк барих	4500.0	4500.0
3	Мал угах зөөврийн ванна		
4	Дотуур байрны зөөлөн эдлэл шинэчлэх	1500.0	1500.0
5	"Эрүүл мэндийн эрсдлийг буруулах эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих" дэд хөтөлбөр	3000.0	3000.0
6	Хүүхэд бүр Цэцэрлэг" хөтөлбөр	1500.0	1500.0
7	Хүүхдийн Цэцэрлэгийн цонхны их засвар	2000.0	2000.0
8	Багшийн хөгжил хөтөлбөр	4500.0	4500.0
9	" Номын гэгээ" хөтөлбөр	200.0	200.0
10	" Хүүхдийн авъяас" хөтөлбөр	2000.0	2000.0
11	Баяр наадмын зардал	5000.0	5000.0
12	ИТХ-ын хөтөлбөр арга хэмжээ	2000.0	2000.0
13	Төсөл, арга хэмжээ	23124.4	23124.4
	Дүн	57124.4	57124.4

Ховд сумын ОНХС нь 2019 онд 16 ажилд 66845.0 мянган төгрөг батлагдаж, 16 нэр төрлийн ажлаа бүрэн санхүүжүүлсэн гүйцэтгэлтэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

д/д	Тухайн жилд худалдан авах бараа ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
-----	--	------------------	-----------

1	Сумын төвийн гудамж талбайн камержуулалт	9000.0	9000.0
2	Ерөнхий боловсролын сургуулийн гадаад додоод орчины камержуулалт	3000.0	3000.0
3	ЭМТ-т notebuuk худалдан авах	2500.0	2500.0
4	Улаанбураа багийн барилгын их засвар	24000.0	23951.1
5	"Зөв хөдөлмөрч залуучуудыг дэмжих" хөтөлбөр /өндөр уулын чиглэлийн зам засах/	11000.0	11000.0
6	"Газар тариалан" хөтөлбөр	1000.0	1000.0
7	"Бэлчээрийн менежментийн" төлөвлөгөө	1000.0	1000.0
8	"Ахмадаа ачлая" хөтөлбөр	1000.0	1000.0
9	"Олон үндэстэн ястны өв соёл" хөтөлбөр	2000.0	2000.0
10	"Тайван-амгалан -Ховдчууд" хөтөлбөр	1600.0	1600.0
11	"Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих" арга хэмжээ	1000.0	1000.0
12	"Авьяас" хөтөлбөр	1345.0	1345.0
13	"Залуучуудын хөгжлийг дэмжих" хөтөлбөр	1000.0	1048.9
14	Цагдаагийн байрны халаалт	3500.0	3500.0
15	Цайны зам хөтөлбөр	1900.0	1900.0
16	Сумын ахмадын хорооны алдарын танхимийг тохижуулах	2000.0	2000.0
	Дүн	66845.0	66845.0

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

1. Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/56 тоот захирамжаар боом өвчний үед зарцуулсан 0.2 сая төгрөгийн шатахууны үнэ төлсөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60.3.1 дэх заалтыг

2. Хог цэвэрлэгээнд аж ахуй нэгжид шилжүүлсэн 0,3 төгрөгийн зардал нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 60.4 дэх заалтыг

3. Хувь хүний хувийн харилцах руу шилжүүлсэн 0.05 сая төгрөгийн бэлэг дурсгалын үнэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.1 дэхь заалт, Төсвийн тухай хуулийн 60.3.3 дахь заалтыг

4. Аймагт зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээний бооцооны мөнгө 0.1 сая төгрөг олгосон нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 60.4 дэх заалтыг

5. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулахаар баталсан 1.0 сая төгрөгийг шатахуунд зарцуулсан нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 60.4 дэх заалтыг

6. Зөв хөдөлмөрч залуучуудыг дэмжих хөтөлбөрт 11.0 сая төгрөг батлан 4.0 сая төгрөгөөр экскаватор ажиллуулан далан засаж “аж ахуй нэгжрүү шилжүүлсэн нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60.3.4 дэх заалтыг тус тус зөрчсөн.

Дээрх зөрчлүүдтэй холбоотой 5,812,100 төгрөгийн зөрчил илэрснээс 1,062,100 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод оруулахаар шийдвэрлэж, улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 4,750,000 төгрөгийн зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй, зөрчлийг арилгуулахаар шийдвэрлэв.

Дүгнэлт:

Ховд сумын ОНХСангаас 2016-1018 онд хийгдсэн ажлуудад шууд гэрээ байгуулан ажилласан бөгөөд ихэнх нь бага дүнтэй 10.0 саяаас доош ажлууд хийгдсэн ба багийн иргэдийн нийтийн хурлаас эрэмбэлсэн саналын хүрээнд томоохон хөрөнгө оруулалт, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдаж авах, багуудын мал угаах ванн, хашаа барих, засах зам, суваг шуудуу татах засварлах зэрэг ажлуудад шууд гэрээ байгуулан санхүүжүүлж ажилласан байна.

Хөтөлбөр нэрээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Засаг даргын удирдлагыг хэрэгжүүлэх зардал мэтээр зарцуулсан байна. Авъяас хөтөлбөр, Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах хөтөлбөр, хамтарсан баг хөтөлбөр, уулын зам засварын ажлуудыг хэрэгжүүлэхэд Засаг даргын удирлагыг хэрэгжүүлэх зардлууд гарсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дах хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөж чадаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх, сангийн хөрөнгийг иргэдийн амьжиргааг дэмжих, ажлын байр бий болгох, хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан хөрөнгө оруулалтын ажил, хөтөлбөрт зарцуулах зөвлөмжүүд өгч ажиллаа.

5.4 Сум хөгжүүлэх сангийн талаар

Засгийн газрын 153-р тогтоолын дагуу жижиг дунд үйлдвэрлэл шинээр байгуулах буюу үйл ажиллагаа нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгох зорилтын дагуу зээлийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг Сумын ИТХ-ын 2013 оны 04 сарын 04-ны өдрийн 13 тоот тогтоолоор сумын Засаг дарга ахалж, гишүүдэд ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, Тамгын газрын нягтлан бодогч, иргэний төлөөлөл, Баялаг бүтээгчийн холбооны гишүүн нарыг оролцуулан бүгд 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг сумын ИТХ-ын 2013 он 02 сарын 05-ний өдрийн 10 тоот тогтоолоор шинэчлэн, сумын ИТХ-ын тэргүүлэгч ахалж, гишүүдэд Төрийн сангийн төлөөлөгч, Иргэний төлөөлөл, Баялаг бүтээгчдийн холбооны төлөөлөл бүхий бүгд 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан байна.

Сум хөгжүүлэх сан нь 2016 оны эхний үлдэгдлээр 18.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 2016 онуудад зээл, зээлийн хүүгийн орлогоор 4.2 сая төгрөг бүрдүүлж, 2016 оны эцэст харилцах дансандаа 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2017 онд: ИТХ-ын №03 тоот тогтоолоор 40.0 сая төгрөг төсөвлөж, оны эхэнд 1.5 сая төгрөгийн дансанд үлдэгдэлтэй гүйцэтгэлээр 16.4 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, 17.9 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Тус онд иргэдэд зээл олгогдоогүй байна.

Доорх хүснэгтэд байгаа 6-н зээл шүүхийн шатандаа явж байна.

№	Овог нэр	Авсан огноо	Авсан зээл	Төлөх хүү	Нийт төлөх зээл, хүү	Нийт төлсөн зээл, хүү	Үлдэгдэл	тайлбар
1	Х.Хумархан	2011.08.10	13700000	689641	14389641	1318038	571603	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд явж байгаа
2	Ш.Ерболат	2013.05.16	15000000	712761	15712761	257460	15455301	
3	С.Ивагат	2013.05.16	5000000	232295	5232295	4236386	995909	
4	С.Кулимхан	2013.05.16	15000000	639067	15639067	3235260	12403807	
5	Х.Карави	2013.05.16	10000000	483991	10483991	3371387	7112604	
6	А.Буланхан	2013.05.16	15000000	717034	15717034	1641067	14075967	
Дүн			73700000	3474789	77174789	26559598	50615191	

Сум хөгжүүлэх сангаас зээл авч хугацаандаа зээлээ төлөөгүй дараах иргэдэд алданги тооцож, Шүүхийн байгууллагад 2017 онд шилжүүлж ажилласан.

2019 онд зээл, зээлийн хүүгийн төлөлтөөс 50.6 сая төгрөгийн орлого орж, 140.0 сая төгрөгийн зээл олгож, 1.3 сая төгрөгийн зарлага гаргаж өнөөдрийн байдлаар 4.7 сая төгрөгийн дансны үлдэгдэл байна.

2016 онд хяналт шалгалтанд шатахууны үнэ 70.0 мянган төгрөг, хоолны зардал 314.5 мянган төгрөг, 2017 онд 1100.0 мянган төгрөг шатахууны зардалд,

2018 онд сум хөгжүүлэх сангийн бүртгэлийн программ 750.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. 2019 онд 1284.0 мянган төгрөгийн шатахуун, хоолны зардалд тус тус зарцуулсан байна.

Дүгнэлт:

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.

Өгсөн зөвлөмж:

Хууль, шүүхийн байгууллагаар шалгагдаж байгаа иргэдийн зээлийг бүрэн төлүүлэхэд хамтран ажиллаж, шинээр зээл олгосон иргэдийн зээлийн зориулалт, үйл ажиллагаанд тогтмол хяналт хийж, зээлийг графикийн дагуу төлүүлэхэд анхаарах, зээлтэй иргэдийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулах талаар шат шатандаа хүсэлт гаргаж, шийдвэр гаргах түвшинд уламжлах, шийдвэрлүүлэх шаардлагатай байгааг анхаарах.

5.5 Сумын эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн төвийн төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2016 онд улсын төсвөөс 280426.6 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж, улсын төсвөөс 280426.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 151.0 мянган төгрөг, нийт 280577.6 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж, захиран зарцуулсан байна.

Авлага 2016 оны эхэнд авлага 298.3 мянган төгрөг байснаа оны эцэст 1713.2 мянган төгрөг болж 1414.8 мянган төгрөгөөр, оны эхэнд өр төлбөргүй байснаа оны эцэст 1417.3 мянган төгрөг болж 1417.3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Үндсэн хөрөнгө 2016 онд 155215.5 мянган төгрөг байснаа 173281.0 мянган төгрөг болж 18065.50 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тус онд 35435.0 мянган төгрөгийн хөрөнгө шинээр нэмэгдсэн, 17369.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулж данснаас хасчээ.

2017 онд улсын төсвөөс 285472.6 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 285472.6 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Авлага 2017 онд оны эхэнд 1713.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 1917.1 мянган төгрөг болж 203.9 мянган төгрөгөөр өссөн, өглөг оны эхэнд 1417.3 мянган төгрөг байсан бол оны эцэст бүрэн барагдуулж өр төлбөргүй болсон байна.

Үндсэн хөрөнгө 2017 онд 173201.0 мянган төгрөг байснаа оны эцэст 157544.7 мянган төгрөг болж 15736.2 мянган төгрөгөөр бууржээ.

Тус онд 1926.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 13809.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулж данснаас хасчээ.

2018 онд улсын төсвөөс 292022.6 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 292022.5 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Авлага 2018 онд оны эхэнд 1917.1 мянган төгрөг байснаа оны эцэст 1136.4 мянган төгрөг болж, 780.6 мянган төгрөгөөр буурсан, оны эхэнд өглөггүй байсан бол оны эцэст 856.0 мянган төгрөг болж 856.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө 2018 онд 157544.7 мянган төгрөг байснаа оны эцэст 164985.3 мянган төгрөг болж 7440.6 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр 12098.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, шинээр 11034.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн 15692.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж данснаас хасчээ.

2019 онд төсвөөс 393290.0 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 376933.9 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Авлага 2019 оны эхэнд 1136.4 мянган төгрөг байсан бол оны эцэст 536.2 мянган төгрөг болж 600.2 мянган төгрөгөөр буурсан, өглөг оны эхэнд 856.0 мянган төгрөг байсан бол оны 149.1 мянган төгрөг болж 706.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө 2019 онд 164985.3 мянган төгрөг байснаа оны эцэст 158000.1 мянган төгрөг болж 6985.2 мянган төгрөгөөр бууржээ.

Тус онд 9666.8 мянган төгрөгийн хөрөнгө шинээр нэмэгдэж 503.4 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 16148.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулж данснаас хасчээ.

Орон тоо 24 ажилтантайгаар батлагдаж 2016-2018 онд 23 орон тоотой 4 гэрээт ажилтантайгаар ажиллаж иржээ.

Өмнөх шалгалтын талаар:

2016-2018 онуудад санхүүгийн тайланд аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 24.5 сая төгрөгийн эмийн тайлан гаргаагүй, орлого бүртгээгүй зөрчил илрүүлж, зөвлөмж өгсөн байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал дансны түлш, шатахуун, эм, хоол, бичиг хэргийн материалуудад тулган баталгаажуулалт хийж, 17.6 сая төгрөгийн бараа материалыг орлогод бүртгээгүй, хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгө, нөхөж байгуулсан элэгдэл, үндсэн хөрөнгийг данснаас хассаны гарз зэрэг 54.3 сая төгрөгийн зардлыг илүү тооцоолж тайлагнасан байсан зэрэг зөрчлүүд илрүүлж, зөвлөмж өгсөн, цалинг зөрүүтэй тооцож 481804 төгрөг илүү олгосон, ХХОАТ суутгаагүй 690067 төгрөг, засвартай баримтаар мөнгө

шилжүүлсэн 324000 төгрөг, эмийн үнэ илүү шилжүүлсэн 400000 төгрөг, нийт 1895871 төгрөгийн акт тогтоож 2019 онд төсвөөс барагдуулсан байна.

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, их засвар хийсэн барилга болон дахин үнэлээгүй 1 хөрөнгөөр зөрүүтэй тайлагнасан, бүртгэл хөтлөлт хангалтгүй, бараа материалын тайлан тооцоо зөрүүтэй зэрэг зөрчил илрүүлж зөвлөмж өгсөн байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар эзэн холбогдогч тодорхойгүй 298.3 мянган төгрөгийн авлага бүртгэсэн, шатахууны тооцоог тухай бүр бодоогүйгээс 417.9 мянган төгрөгийн шатахууныг үндсэн нормоос илүү зарцуулсан, бараа материалын орлого, зарлагыг программд тоо ширхэг, бэлтгэн нийлүүлэгч бүрээр тусгалгүй бөөн дүнгээр орлого авч зарлага гаргасан, бэлтгэн нийлүүлэгчдийг хооронд нь солисон зэрэг зөрчлүүд илрүүлж, зөвлөмж өгч зөрчлийг арилгуулахаар шийдвэрлэсэн байна.

Ховд аймгийн татварын хэлтсээс 2012-2014 оны санхүүгийн баримтанд 2015 онд татварын хяналт шалгалт хийж, 1488643 төгрөгийн нөхөн татвар, 446593 төгрөгийн торгууль, 301070 төгрөгийн алданги, нийт 2236306 төгрөгийн татварын акт тогтоож, төсвөөс барагдуулжээ.

Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2017-2018 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдалд 2019 онд хяналт шалгалт хийж, 1314205 төгрөгийн НДШ, 657102 төгрөгийн алданги, нийт 1971307 төгрөгийн акт тогтоож төлүүлсэн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрлээ.Үүнд:

1. Галч нарт хор саармагжуулах бүтээгдэхүүнийг бэлэн мөнгөөр олгож байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалт, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дугаар тушаалыг 1 дэх заалтыг

2. 2019 оны 11, 12 дугаар саруудад нэр бүхий 2 ажилтанд ажил хавсарсны нэмэгдлийг илүү тооцож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтуудыг

3. 2017-2018 оны 6 дугаар сарын хооронд сувилагчид хөдөө орон нутагт ажилласны нэмэгдлийг 20 хувиар тооцон 352.3 мянган төгрөг, 2018 оны 8-12 дугаар саруудад Сувилагчид хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэлд 20 хувиар

тооцон 119.8 мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2001 оны 90 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг

4. 2016-2019 оны хооронд нэр бүхий 11 ажилтанд 564.8 мянган төгрөгийн ээлжийн амралт, цалин хөлсийг давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалтуудыг

5. 2018 оны 10,11,12 дугаар саруудад галч нарт ТҮ-2-1 дүгээр шатлалаар тооцон цалинжуулж, 205.9 мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтыг

6. 2017 онд 4 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан байхад 2017 оны 12 дугаар сард Монгол улсын Засгийн газраас төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн урамшуулалд тус бүр 270.0 мянган төгрөг, нийт 1080.0 мянган төгрөг олгосон нь Улсын Их Хурлын 2017 оны 67 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг

7. 2018 оны 8 дугаар сард Эрхлэгч эмчийн А/14 дүгээр тушаалаар Дарви, Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн ойд 210.0 төгрөг, 2019 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн эрхлэгчийн А/13 дугаар тушаалаар 117.0 төгрөгийн хандив Мэс заслын тасагт, 2019 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар өрхийн эмнэлэгт 99000 төгрөгийн хандив, нийт 426.0 төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь заалтыг

8. 2019 онд улирал бүр ажлаа дүгнэн, сар бүрийн үр дүнгийн урамшууллаа дараа улиралдаа олгосон байхад 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/18 дугаар тушаалаар жилийн эцсийн үр дүнгийн урамшуулалд 2944.8 төгрөг илүү тооцож олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.6, 3.7 дугаар заалтуудыг

9. 2018 онд Аудитын газраас 1895.8 мянган төгрөгийг хүмүүсээр төлүүлэхээр акт тогтоосноос 2018 онд 131.3 мянган төгрөг суутгаж 2019 онд уг актын үлдэгдэл 1764.5 мянган төгрөгийг төсвөөс барагдуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг

10. Нярав хүнсний материал бэлтгэхдээ анхан шатны баримт бүрдүүлээгүй байхад нягтлан бодогч гүйлгээ хийж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь заалтуудыг

11. 2019 онд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолгүйгээр хөрөнгө бэлтгэж, орлогод авсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг

12. Тус онуудад 9 ширхэг, 1495.0 мянган төгрөгийн дугуй, 189.0 төгрөгийн аккумулятор, бусад сэлбэг хэрэгсэл худалдан авч, тавьж олгохдоо тооцоо бодоогүй, техникийн бүртгэл, хувийн хэрэг хөтөлдөггүй, шатахууны тооцоо нийлсэн актгүй, гадны машинд болон тээврийн зардалд зарцуулсан шатахууны тооцоо бодож

замын хуудас бичээгүй, өр авлагын тооцоо хийж баталгаажуулаагүй, хоол, эмийн тайлан, нүүрс, түлшний тайланг стандартын дагуу гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтууд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 19 тоот тушаал, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалуудыг

13. Архив албан хэрэг хангалтгүй хөтлөгдөж байгаа бөгөөд тус байгууллагын даргын тушаал баримтанд байгаа тушаалуудын дугаар санхүүгийн баримтанд байгаа тушаалуудын дугаараас зөрсөн, санхүүгийн баримтанд байгаа зарим тушаалууд, архивт байхгүй, тушаалын үндэслэх хэсэгт хуулийн хүчингүй заалтууд бичсэн зэрэг зөрчлүүд илэрч байна.

Дээрх зөрчлүүдтэй холбоотой нийт 51 хүн байгууллагтай 9,306,369 төгрөгийн зөрчил илэрснээс 7,622,369 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод оруулахаар шийдвэрлэж, улсын байцаагчийн акт тогтоолоо. 1,684,000 төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж, хугацаатай үүрэг өглөө.

Дүгнэлт:

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт суларсан, бараа материалын тайлан нэн ялангуяа эмийн тайлан, шатахуун, түлш, тайлан гаргалт, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулаагүй, хандив тусламж зэрэгт зарцуулсан нь төсвийн тухай хуулийн тодорхой заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн төв нь Галч нарт хор саармагжуулах бүтээгдэхүүнийг олгохдоо Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалт, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дугаар тушаалыг 1 дэх заалтыг мөрдөж, ажиллах, бараа материал, сэлбэг хэрэгсэл, шатахууны тооцоог сар, улирал бүр хийж хэвших, Төсвийн байгууллагуудад зарцуулж байгаа нүүрсийг олгосон жагсаалтыг өдөр бүр үйлдэж тооцоо хийх, анхан шатны баримт бүрдээгүй ажил гүйлгээг хийхгүй байх, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөх, санхүүгийн жилд үүссэн өр, авлагыг барагдуулах, хойшид авлага, өр төлбөр үүсгэлгүй санхүүгийн хариуцлагатай ажиллах, цалин хөлсийг тайлант оны эхэнд тогтоох, түүний дагуу бодож, тооцооллын алдаа гаргахгүй байхад анхаарах, бараа материалын тайланг стандартын дагуу үнэн зөв гаргах, НББОУС, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжинд нийцүүлэн бэлтгэх, төрийн бусад байгууллагуудад хандив өгөхийг таслан зогсоох зэрэг зөвлөмж өгсөн байна.

5.6. Ерөнхий боловсролын сургууль

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Тус сургууль нь 2016 онд улсын төсвөөс 784964.7 мянган төгрөг, өөрийн орлогоор 500.0 мянган төгрөг, 785464.7 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 781964.7 мянган төгрөг, өөрийн орлогоор 699.0 мянган төгрөг, бүгд 782663.7 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

2016 онд тус байгууллага нь өр авлагагүй гарсан байна.

Үндсэн хөрөнгө оны эхний үлдэгдэл 1917293.8 мянган төгрөг байсан бол оны эцэст 2083961.5 мянган төгрөг болж өссөн байна. Тоног төхөөрөмж 9206.7 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 5939.9 мянган төгрөгөөр, ном 775.0 мянган төгрөгөөр, Барилга байгууламж 154066.0 тус тус нэмэгдэж, 3319,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж 579432.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

2017 онд улсын төсвөөс 882472.2 мянган төгрөг, өөрийн орлогоор 500.0 мянган төгрөг нийт 882972.2 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 882472.2 мянган төгрөг, өөрийн орлогоор 231.6 мянган төгрөг, бүгд 882703.8 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

2017 оны эхэнд авлагагүй байсан бол оны эцэст 918.6 мянган төгрөгийн авлагатай болсон байна.

2017 онд өр төлбөр үүсгэлгүй ажилласан байна.

Үндсэн хөрөнгө оны эхний үлдэгдэл 2083961.5 мянган төгрөг байсан бол оны эцэст 2085225.3 мянган төгрөг болж өссөн байна. Тоног төхөөрөмж 12361.8 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 879.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж 11977.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж, 633090.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

2018 онд улсын төсвөөс 843534.0 мянган төгрөг, өөрийн орлогоор 500.0 мянган төгрөг нийт 844034.0 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 847474.4 мянган төгрөг, өөрийн орлогоор 300.0 мянган төгрөг бүгд 847774.4 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

2018 оны эхэнд 918.6 мянган төгрөгийн авлагатай байсан бол оны эцэст авлагагүй болсон байна.

2018 онд өр төлбөр үүсгэлгүй ажилласан байна.

Үндсэн хөрөнгө оны эхний үлдэгдэл 2085225.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 1957391.3 мянган төгрөг болж буурсан байна. Барилга байгууламж 654169.6 мянган төгрөг, тоног төхөөрөмж 7444.5 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 8285.5 мянган төгрөгөөр, биет бус хөрөнгө 44988.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

2018 онд хөрөнгийн дахин үнэлгээ хийж 629809.7 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг нэмж 281845.9 мянган төгрөгийн дахин үнэлгээний хорогдлыг хассан байна.

Тус онд 4949.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 555926.0 мянган төгрөгийн барилга байгууламжийг акталж, 196953.3 мянган төгрөгийн элэгдэл байгууджээ.

2018 онд Ерөнхий боловсролын сургуулийн 70 жилийн ой тэмдэглэх арга хэмжээнд нийт 21296.3 мянган төгрөгийн хандив цугласан байна.

Хандивыг дараах арга хэмжээнд зарцуулжээ. Үүнд:

Д/д	Зарцуулалт	Дүн
1	Сургуулийн түүхэн ном 500 ширхэг хэвлүүлэн төгсөгч нарт хандивласан гарын бэлэг олгосон	Хандив
2	Баяр наадмын шагналд	9500000
3	Төгсөгч нарын 5 удаагийн дайллаганд	9880350
4	Багш хөгжлийн төвийг тохижуулахад Мөнгөн трейд ХХК-иас EPSON-3118 3 ш өнгөт принтер	1140000
5	чанга яригч 2 ширхэг	376000
6	спорт заалны лед гэрэл 8 ш	400000
	ДҮН	21296350

Сургуулийн 70 жилийн ойн хүрээнд хандиваар ирсэн эд хөрөнгө тоног төхөөрөмжийг байгуулагдсан баярын комиссоор тогтоолгон 10914.2 мянган төгрөгөөр орлого авахуулан ажилласан байна.

2019 онд улсын төсвөөс 943873.4 мянган төгрөг, өөрийн орлогоор 135.0 мянган төгрөг, нийт 986333.2 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 943873.4 мянган төгрөг, өөрийн орлогоор 135.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 46011.7 мянган төгрөг бүгд 990020.1 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

Нэмэлт санхүүжилтээр 17444.2 мянган төгрөгөөс нөөц хөрөнгөөс тухайн захирагчийн 11223.6 мянган төгрөг, доод шатны төсвийн захирагчийн хуваарилсан хөрөнгө 3270.0 мянган төгрөг, нэмэлт орлого 2950.6 мянган төгрөг нэмэлт санхүүжилтээр санхүүжүүлж үндсэн цалинд 6719.0 мянган төгрөг нэмэгдэлд 4344.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 430.6 мянган төгрөг зарцуулжээ.

2019 оны эхэнд авлагагүй байсан бол оны эцэст 2919.4 мянган төгрөгийн авлагатай болсон байна.

2019 оны эхэнд өр төлбөр байхгүй байсан бол 2019 оны эцсийн үлдэгдэл 798.2 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгө оны эхний үлдэгдэл 1957391.3 мянган төгрөг байсан бол оны эцэст 1965494.4 мянган төгрөг болж өссөн байна. Тоног төхөөрөмж 12118.0 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 2250.0 мянган төгрөгөөр, Програм хангамж 457.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ. Тус онд 3378.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3343.2 мянган төгрөгийн тавилага эд хогшлыг акталж, 2346047 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ

Өмнөх шалгалтын талаар:

2016-2019 онуудад санхүүгийн тайлангийн аудитаар: “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгчээ.

2019 онд сургуулийн захирлаар Д.Манат, сургалтын менежер Я.Өмирхан, Б.Күншуах, нягтлан бодогчоор Х.Бүлдиршин нар ажиллаж байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Шалгалтаар 2019 онд санхүүгийн тайлан балансаар НДШ-н авлага 1447.1 мянган төгрөг, ХХОАТ-ын авлага 1472.3 мянган төгрөг нийт 2919.5 мянган төгрөгийн авлагыг тооцон баталгаажуулаагүй цалингийн сангийн хэмнэлтийг илүү шилжүүлсэн нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дахь заалтуудыг

2. Монгол Улсын Засгийн Газрын тогтоол зөрчиж, 2019.06.14-ний А/47 тоот сургуулийн захирлын тушаалаар 549.9 мянган төгрөгийг багш ажилчдын идэвхтэй амралтанд төсвөөс хүүхдийн хоолны зардлаас гаргаж тухайн байгууллагын төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 147-р тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын 2.в.5 дах заалт, Сангийн сайдын 2014 оны 122 тоот тушаалын нэг дэх хэсгийн 4 дэх заалтыг

3. 2018 онд сургуулийн 90 жилийн ойн баримтаас нэр бүхий комиссоор ажилласан 11 хүнд олгосон урамшуулалт цалингаас Хувь хүний орлогын албан татвар суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.7 дах заалтууд, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.6 дах заалт, Монгол улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг

4. 2019.08.26-ний өдрийн А/48 тоот сургуулийн захирлын тушаалаар дотуур байрны гал тогооны дүүжин таазыг хүүхдийн хоолны зардлаас, ажилчдын нормын хувцасыг бэлэн мөнгөөр олгосон 1674.0 мянган төгрөг, сургуулийн сангийн зардал 2391.0 мянган төгрөг олгосон боловч ажил хийгдээгүй, бусад 666.5 мянган төгрөг нийт 7601.9 мянган төгрөгийг тайлант жилд хоолны зардлаас гаргаж урсгал зардлаар тайлагнаж бага үнэтэй түргэн элэгдэх хөрөнгийг байгууллагын данс бүртгэлд тусгаж орлого аваагүй нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дахь заалтыг

5. Нягтлан бодогч нь сургуулийн төсөвт урамшуулал тусгагдаагүй байхад 2016, 2017, 2018 онуудад ур чадвар, үр дүнгийн нэмэгдэлд олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтууд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 63/104 тоот тушаалын хавсралтын 3, 4 дэх заалтыг

6. Сургуулийн Захирал сахилгын шийтгэлтэй, урамшуулал олгох захирамж шийдвэргүй байхад 2019 онд ур чадвар, үр дүнгийн урамшуулалд 249.2 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолын хавралтын 2.5 дахь заалтыг /аймгийн Төрийн аудитын газраас акт тогтоосон./

7. Сургуулийн захирал нь төсөв хүрэлцэхгүй байхад байгууллагын дотоод журам, ур чадварын нэмэгдэл олгох журамд заасны дагуу гэж ур чадварын нэмэгдэл, ажил хавсарсны нэмэгдэлийг тушаал гаргаж өр үүсгэн хүүхдийн хоолноос тодотголоор захирамж гаргуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтуудыг

8. Галч нарт нормын хувцас 2019 онд 1674.0 мянган төгрөг, хор саармагжуулах бүтээгдэхүүнийг бэлэн мөнгөөр олгож байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалт, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дугаар тушаалыг 1 дэх заалтыг

9. Сургуулийн хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийхэд тэтгэвэрт гарсан 2 багш, жилийн чөлөө авсан багш нарын компьютер байхгүй байсныг шалгалтын хугацаанд авахуулан кодтой тулган нярав нягтлан бодогч нарт хүлээлгэн өгсөн. Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.1 дэх заалт, 73 дугаар зүйлийн 73.4 дэх заалтуудыг

10. Сургуулийн захирлын 2019.06.13-ний тушаалаар 3564.0 мянган төгрөг, мөн 2019.10.17-ний өдөр 932.4 мянган төгрөг нийт 4496.4 мянган төгрөгийг хүүхдийн хоол хүнснээс дээд байгууллагын эрх зүйн баримтгүй аймгийн БСГ-аас зохион байгуулсан физикийн олимпиад уралдаан тэмцээний багш нарын хоол хүнсэнд захиран зарцуулсан байна.

11. 2019 оны 12 дугаар сард $500\text{кг} \times 1500 = 750000$ төгрөгөөр манжин худалдан авсан, 2020 оны 1-4 сард хоол хүнсэнд онцгой шалтгаанаар зарцуулагдаагүй агуулах складын үлдэгдэл $456 \times 1500 = 684000$ төгрөгийн манжинг сумын болон сургуулийн үнэ тогтоох комиссоор оруулан яаралтай зарж сургуулийн орлогод тушаан 9 дүгээр сард хямд үнэтэй хүнсний ногоогоор хангаж ажиллах.

Энэ удаагийн шалгалтаар 152 хүн, байгууллагатай холбоотой 14,514,124 төгрөгийн зөрчил илрүүлж, 7,601,905 төгрөгийг тухайн байгууллагын данс бүртгэлд тусгаж орлого авахуулахаар, 6,912,219 төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар улсын байцаагчийн акт тогтоолоо.

Дүгнэлт:

2016-2019 онуудад тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт суларсан, бараа материалын тайлан нэн ялангуяа хоол хүнсний тайлан шатахуун, түлш, бичиг хэргийн материал урсгал зардлын тайлан гаргалт, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй шууд зардалд бичиж тайлагнасан байна. /Шалгалтын хугацаанд бичиг хэргийн хүүхдийн хувьсах зардлын тооцоо ирээгүй./

Өгсөн зөвлөмж:

Сургууль нь санхүүгийн жилд үүссэн өр, авлагыг барагдуулах, хойшид авлага, өр төлбөр үүсгэлгүй санхүүгийн хариуцлагатай ажиллах, төсвийн байгууллагуудад зарцуулж байгаа нүүрсийг өдөр бүр олгосон жагсаалт үйлдэж, шатахуун болон нүүрсний тайлан, бараа материал, бичиг хэргийн зардлыг сар улирлаар гаргаж хэвших, төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан санхүүгийн жилийн эхэнд тогтоон, мөрдөж ажиллах, хэмнэгдсэн төсвийг гүйлгэн зарцуулахдаа Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах, төсвийн хэмнэлтийг зориулалтын дагуу төвлөрүүлэн зарцуулах ба өр авлага үүсгэж өөр зардалд шилжүүлдэг асуудлыг таслан зогсоох. Төсвийн үрэлгэн байдал гаргахгүй байж, 2014 оны Засгийн газрын 147 дугаар тогтоолыг мөрдөж хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллах, 2019 оны 12 дугаар сард худалдан авсан манжинг сумын болон сургуулийн үнэ тогтоох комиссоор оруулан яаралтай зарж мөнгөн дүнг сургуулийн орлогод тушаан 9 дүгээр сард хямд үнэтэй хүнсний ногоогоор хангаж ажиллах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөх, төрийн өмч бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тушаал шийдвэргүйгээр аливаа хөрөнгө борлуулах, данснаас хасахгүй байх зөвлөмжүүдийг өглөө.

5.7 Хүүхдийн цэцэрлэг

Цэцэрлэгийн төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2016 онд улсын төсвөөс 205642.4 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 205642.4 мянган төгрөгийг зарцуулжээ.

Авлагын эхний үлдэгдэл 59.7 мянган төгрөг байсан ба оны эцэст 98.3 мянган төгрөгийн авлагатай гарсан байна. Тус байгууллага 2016 онд өр төлбөр үүсгэлгүй ажилласан байна.

Үндсэн хөрөнгө оны эхний үлдэгдэл 307506.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 309066.3 мянган төгрөг болж өссөн байна.

2017 онд улсын төсвөөс 179619.2 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 179571.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

Тайлант онд авлагын эхний үлдэгдэл 98.3 мянган төгрөг байсан ба оны эцэст 653.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхэнд өр төлбөргүй байсан ба оны эцэст 2020.7 мянган төгрөгийн өртэй болсон байна.

Үндсэн хөрөнгө 2017 онд 309066.3 мянган төгрөг байснаа 307414.6 мянган төгрөг болж 1651.7 мянган төгрөгөөр буурсан байна.

2018 онд улсын төсвөөс 185453.5 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 186213.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Авлагын эхний үлдэгдэл 653.0 мянган төгрөг байсан ба оны эцэст 459.2 мянган төгрөгийн авлагатай байна. 2018 оны өр төлбөрийн эхний үлдэгдэл 2020.7 мянган төгрөг байсан бол оны эцэст өр төлбөрийг бүрэн барагдуулж ажилласан байна.

2019 онд улсын төсвөөс 232504.9 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр 232504.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Авлагын эхний үлдэгдэл 459.2 мянган төгрөг байсан ба оны эцэст 443.3 мянган төгрөгийн авлагатай байна. 2018 оны өр төлбөргүй байсан бол оны эцэст өр төлбөр 29.7 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгө 2019 оны эхэнд 237207.3 мянган төгрөг байснаа 244932.4 мянган төгрөг болж өссөн байна.

Өмнөх шалгалтын талаар:

2016-2018 оны санхүүгийн тайлан балансыг УСНББОУС-д нийцүүлэн бэлтгэж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2016-2019 оны зарим өдрийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны цэсийг зөрчиж цэсэнд байхгүй хоол хүнсний материал болох боз, цагаан будаа, гурвалжин будаа, сүү, үхрийн мах зэрэг 587.2 мянган төгрөгийн хүнсний материалыг хүүхдийн хоолны талонд зарлага болгосон нь Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/296 тоот тушаалын хоёрдугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг

2. 2016 оны 11 дүгээр сарын 28-нд 48.4 мянган төгрөг, 12 дугаар сарын 20-нд 37.8 мянган төгрөг, 12 дугаар сарын 21-нд 96.0 мянган төгрөг, 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр 93.0 мянган төгрөгийн шатахууныг жолоочийн тооцооны хуудасгүй, нэхэмжилсэн дүнгээс илүү шилжүүлсэн, зориулалт бусаар зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтууд, санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 дүгээр тушаал, Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 19 тоот тушаалуудыг

3. 2016 оны 01, 02, 03, 09, 10, 12 дугаар саруудын 29298.8 мянган төгрөгийн, 2017 оны 02, 04, 05, 10, 11 дүгээр саруудын 7836.3 мянган төгрөгийн, 2018 оны 2, 3, 11, 12 дугаар саруудын 1855.3 мянган төгрөгийн, 2019 оны 02 дугаар саруудын 256.4 мянган төгрөгийн зарим төлбөрийн хүсэлт болон санхүүгийн баримтанд даргын тамга тэмдэг гарын үсэг дутуу, зарим бараа материалыг хоосон нэхэмжлэл хавсарган олгосон, нярав орлогод авсан баримтгүй, анхан шатны баримт дутуу үйлддэг, Сургуулийн багшид цэцэрлэгийн төсвөөс цалингийн урьдчилгаа олгосон зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.5, 7.6, 7.7 дахь заалтууд, Төрийн сангийн төлбөр тооцооны журамын 7.5, 7.6, 7.7 дахь заалтыг

4. Ажилтан А-аар Аудитын газраас төлүүлэхээр акт тогтоосон байхад 2017 оны 02 сарын 28-ны өдөр 300.0 мянган төгрөгийн актын төлбөрийг төсвөөс төлсөн, мөн тушаал шийдвэргүйгээр 2017 оны 6 сард ур чадварын нэмэгдэлд 274.5 мянган төгрөг, 2019 оны 03 сарын 27-нд ур чадварын нэмэгдэлд 277.5 мянган төгрөг, 2019 оны 06 сарын 26-нд 256.1 мянган төгрөгийн ур чадвар нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолын хавралтын 2.5 дахь заалтыг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг

5. 2016 оны 04-р сард Туслах багш К.Нургүлийг үндсэн багшаар 3 сар ажиллуулсан нь Сургуулийн өмнөх Боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь заалтыг

6. Галч нарт нормын хувцас, хор саармагжуулах бүтээгдэхүүнийг бэлэн мөнгөөр олгож байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалт, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дугаар тушаалыг 1 дэх заалтыг

7. 2016 оны 10 дугаар сарын 14-нд Багш жирэмсэний амралт авсан байхад 10 дугаар сарын цалинг бүтэн бодож 255.4 мянган төгрөг илүү олгосон, мөн 2016 оны 06 сарын 17 нд галч нарт 6 дугаар сарын цалин дээр 229.2 мянган төгрөгийн илүү цаг бодож олгосон, 2017.06.23 өдөр тушаал шийдвэргүйгээр ахлах тогоочид 374.4 мянган төгрөгийн цалин бодсон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заал, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1дэхь заалтуудыг

8. 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хүнсний агуулахын тооллогоор 2 нэр төрлийн 1241.0 төгрөгийн бараа материал дутагдуулсан.

9. 2017 оноос хойш 2 манаач ажиллуулж байгаа нь төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.3 заалт, цэцэрлэгийн орон тооны нормативийг

10. А-д 2017 оны 7 дугаар сард ээлжийн амралтыг 42 хоног буюу 12 хоногоор тооцож 437.9 мянган төгрөг илүү бодогдсон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шалгалтаар нийт 4,868,500 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар шийдвэрлэж улсын байцаагчийн акт тогтоож, шийдвэрлэв.

Дүгнэлт:

Нягтлан бодогч хүнсний тайлан буруу гаргадаг, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгодог, байгууллагын батлагдсан орон тоогоор ажилладаггүй, санхүүгийн сахилга бат сул, төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн хяналт тавьдаггүй, батлагдсан орон тоогоор ажиллаагүй, нярав эрлэгч нар агуулахын үлдэгдэлийг баталгаажуулаагүй зэрэг алдаа дутагдал байна.

Өгсөн зөвлөмж:

Хүүхдийн тоог багшийн ирцийн бүртгэлд үндэслэн нярав, тогооч нар материал зарлагадах ба хүүхдийн хоолны цэсэнд орсон хоолны материалыг зарлага болгож хэвших, байгууллагын менежер ур чадварын болон үр дүнгийн нэмэгдэлийг дээд шатны эрх захирагчийн шийдвэрээр олгох, шатахууны тооцоог сар бүр хийх, замын хуудсыг явсан өдөр, километр бүрээр бичих, жолоочийн тооцоог бодохдоо Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалыг мөрдөж ажиллах, санхүүгийн анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэх, анхан шатны баримт бүрдээгүй гүйлгээг хийхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж ажиллах, батлагдсан орон тоогоор ажиллах зэрэг зөвлөмжүүдийг өглөө.

5.8 Соёлын төв

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2016 онд улсын төсвөөс 50613.4 мянган төгрөг, өөрийн орлогоор 5000.0 төгрөг нийт 55613.4 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж, улсын төсвөөс 55613.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 562.0 мянган төгрөг, нийт 51175.4 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж, захиран зарцуулсан байна

2016 онд өглөг, авлагагүй ажилласан байна.

2016 онд үндсэн хөрөнгө 304275.7 мянган төгрөг байснаа оны эцэст 292187.1 мянган төгрөг болж 12088.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тус онд 155.0 мянган төгрөгийн хөрөнгө шинээр бэлтгэж, 12243.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардалд бүртгэжээ.

2017 онд улсын төсвөөс 53636.0 мянган төгрөг, өөрийн орлогоор 2600.0 төгрөг бүгд 56236.0 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, улсын төсвөөс 53636.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 2271.3 мянган төгрөг, нийт 55907.3 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж, захиран зарцуулсан байна.

Авлага 2017 онд авлага, өр төлбөргүй ажилласан байна.

2017 онд үндсэн хөрөнгө 292187.1 мянган төгрөг байснаа оны эцэст 282031.4 мянган төгрөг болж 10155.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тус онд 2031.0 мянган төгрөгийн хөрөнгө шинээр бэлтгэж, 68.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 12118.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардалд бүртгэжээ.

2018 онд улсын төсвөөс 53502.7 мянган төгрөг, өөрийн орлогоор 2600.0 мянган төгрөг бүгд 56102.7 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, улсын төсвөөс 53502.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 680.0 мянган төгрөг, нийт 54182.7 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж, захиран зарцуулсан байна.

2018 онд эхэнд авлагагүй байсан ба оны эцэст 217.0 мянган төгрөгийн авлагатай гарч, өр төлбөр үүсгэлгүй ажиллажээ.

Тайлант онд үндсэн хөрөнгө 282031.4 мянган төгрөг байснаа оны эцэст 489954.0 мянган төгрөг болж 207922.6 мянган төгрөгөөр өссөн байна. Тус онд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой 220030.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 12108.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардалд бүртгэжээ.

2019 онд улсын төсвөөс 71114.4 мянган төгрөг, өөрийн орлогоор 1500.0 мянган төгрөг, нийт 72614.4 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, улсын төсвөөс 71114.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 1500.0 мянган төгрөг, нийт 72614.4 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж, захиран зарцуулсан байна.

2019 оны эхэнд 217.0 мянган төгрөгийн авлагатай байсан ба оны эцэст 43.1 мянган төгрөгийн авлагатай, оны эхэнд өр төлбөргүй байсан бол оны эцэст 558.4 мянган төгрөгийн өр төлбөртэй болсон байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 489954.0 мянган төгрөг байснаа оны эцэст 459765.1 мянган төгрөг болж 30188.8 мянган төгрөгөөр буурсан байна. Тус онд 3357.0 мянган төгрөгийн хөрөнгө шинээр нэмэгдэж, 606.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 32939.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардалд бүртгэжээ.

Өмнөх шалгалтын талаар:

2017, 2019 онуудад санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй, үнэт цаасны тооцоо тухай бүр хийгээгүй, орлогын төлөвлөгөөг төвлөрүүлээгүй, галч нарын сул зогсолтын үед нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй зэрэг зөрчлүүд илрүүлж, зөвлөмж өгч арилгуулсан байна.

2018 онд 217.0 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг дутуу бүртгэснийг, 2018.12.21-нд Жайсан ХХК-д номны үнэ 1.0 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулж орлогод авахгүй шууд зардалд бичсэн, дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 170.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн, үнэт цаасны тооцоо тухай бүр хийгээгүй, орлогын төлөвлөгөөг төвлөрүүлээгүй зэрэг зөрчлүүд илрүүлж зөвлөмж өгсөн байна.

2019 онд батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, үнэн зөв тайлагнаагүй, төсвийн шууд захирагч, нягтлан бодогчоор хянагдаагүй, зөвшөөрөгдөөгүй шаардах хуудсаар байгууллагын нярав бараа материалын зарцуулалтыг бүртгэж тайлагнасан, няравын дансаар дамжуулж бэлэн мөнгө зарцуулсан байхад анхан шатны баримт бүрдүүлж, гарын үсэг зуруулаагүй, уран бүтээлийн зардлаас зарцуулагдсан үйл ажиллагаанд тайлан, илтгэх хуудса бичиж баталгаажуулаагүй, анхан шатны баримтуудад гарын үсэг зуруулдаггүй, хүчин төгөлдөр байдлыг бүрэн хангаагүй, тухайн онд шинээр нэмэгдсэн 3357.0 мянган төгрөгийн хөрөнгийн холбогдох шийдвэрийг ИТХ-аар гаргуулаагүй зэрэг зөрчлүүд илрүүлж зөвлөмж өгсөн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2018 оны жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн 217.0 мянган төгрөгийн авлагыг тайлан тэнцэлд тусгалгүйгээр үндэслэлгүйгээр хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг

2. 2019 онд Эрхлэгчийн А/05, А/11, А/13, А/14, А/15 дугаар тушаалуудаар Цэцэг, Дарви, Манхан, Үенч сумын Соёлын төв, Боловсрол соёлын газрын ажилтан зэрэгт нийт 255.0 төгрөгийн хандив, тусламж олгосон нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь заалтыг

3. Эрхлэгчийн 2017 оны II/20-ны өдрийн 02 дугаар тушаалаар 3 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан байхад 2017 оны 12 дугаар сард Монгол улсын Засгийн газраас төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн урамшуулалд тус бүр 270.0 мянган төгрөг, нийт 810.0 мянган төгрөг олгосон нь Улсын Их Хурлын 2017 оны 67 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг

4. Галч нарт хор саармагжуулах бүтээгдэхүүнийг бэлэн мөнгөөр олгож байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалт, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дугаар тушаалыг 1 дэх заалтыг

5. Жолоочийн тооцоо бодож баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт, Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 19 тоот тушаалуудыг

6. Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн, ажил гүйлгээг тайлан тэнцэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтуудыг тус тус зөрчжээ.

Энэ удаагийн шалгалтаар нийт 1,012,053 төгрөгийн зөрчил илрүүлж 1,012,053 төгрөгийг орон нутгийн төсөвт төлүүлэлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт:

Төсвийн хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сахилгын шийтгэл ногдуулсан албан тушаалтанд санхүүгийн тайлангийн жилд сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад ажлын үр дүнг тооцож нэмэгдэл олгохгүй байх, үнэт цаасны тооцоог сар улирлаар хийж, орлогын тооцоог бодож баталгаажуулж байх, төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, хандив тусламж өгөхгүй байх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, галч нарт хор саармагжуулах бүтээгдэхүүнийг олгохдоо Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалт, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дугаар тушаалыг 1 дэх заалтыг мөрдөж, бүтээгдэхүүн олгох, төрийн бусад байгууллагуудад хандив өгөхийг таслан зогсоох, бараа материал, шатахууны тооцоог сар, улирал бүр хийж хэвших, анхан шатны баримт бүрдээгүй ажил гүйлгээг хийхгүй байх, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Зургаа. Сумын хэмжээний төсөвт байгууллагуудад хийсэн шалгалтын дүн

Шалгалтаар нийт сумын хэмжээнд 247 хүнтэй холбоотой 35,326,591 төгрөгийн зөрчил илрүүлж 27,724,686 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар 7601905 төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулахаар тус тус шийдвэрлэж, улсын байцаагчийн 29 акт тус тус бичсэн байна.

Төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн албаны дарга нар төсвийн байгууллагуудын гүйлгээ хийхдээ төрийн сангийн хяналтыг хууль эрх зүйн хүрээнд тавиагүй, анхан шатны баримт байхгүй, бүрдээгүй тохиолдолд гүйлгээ хийдэг,

төсвийн тухай хууль зөрчсөн гүйлгээг хийсэн зэрэг нь төрийн сангийн хяналт хангалтгүй, сул байгааг харуулж байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА